
2026 ОНЫ 10 ДУГААР САРЫН УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Манай орны 10 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар -3°C (48.2°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар +3.1°C (53.8°F) –аас +12°C (66.2°F), бусад нутгаар -3.1°C –аас +3°C (48.4°F –аас 53.6°F) дулаан байдаг байна.


Монгол орны хэмжээнд 10 дугаар сард ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 3.2 хувь нь ордог. Тус сард нутгийн хойд, төв болон зүүн хэсгээр 5.1-18 мм, бусад нутгаар 0.3-5 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 10 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны оронзайн тархалт


2026 оны 10 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс 2.2°C-аар дулаан, ОЖД-аас -0.7°C-аар хүйтэн байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 41 дэх хүйтэн болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн 38% нь дунджаас -1.1-ээс -3°C-аар хүйтэн, 62% нь дунджийн орчим байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 7.6 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 26.6%-иар, ОЖД-аас 25.2%-иар ахиу буюу 1940 оноос хойш тохиолдож байгаа 17 дахь ахиу хур тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 42.6% нь дунджаас ахиу, 10.9% нь дунджийн орчим, 46.5%-д дунджаас бага хур тунадас орсон байна.




Зураг 2. 2026 оны 10 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орны хэмжээнд болон дөрвөн бүсээр хуваан дундажлан тооцоолсон 10 дугаар сарын хоногийн агаарын дундаж температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) нийт нутгаар сарын ихэнх хугацаанд буюу 1 дүгээр 10 хоногийн эхэн, 2 болон 3 дугаар 10 хоногийн ихэнх хугацаанд ОЖД-аас 0.5°C -аас 8.6°C-аар хүйтэн байсан бол бусад хугацаанд агаарын температур ОЖД-аас 0.5°C-аас 6.5°C-аар дулаан байлаа. Хур тунадасны хувьд 1 дүгээр 10 хоногт зүүн бүсийн нутгаар, 2 дугаар 10 хоногт нийт нутгаар харьцангуй ахиу, бусад хугацаанд бага хур тунадас орсон байна.



Зураг3. Хоногийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Тус сард агаарын температурын үнэмлэхүй их утга Өмнөговь аймгийн Ханбогд суманд +28.2°C, үнэмлэхүй бага утга Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -31.1°C хүрсэн. Харин хөрсний температурын үнэмлэхүй их утга Говь-Алтай аймгийн Баянтоорой суманд +43°C, үнэмлэхүй бага утга Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -33°C хүрч хүйтэрсэн байна. Хоногт хамгийн ихдээ Сүхбаатар аймгийн Баяндэлгэр суманд 3-ны өдөр 36.2 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 958.4гПА, бага утга Баянхонгорын Баянбулагт 762.2гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их Өмнөговь аймгийн Цогт-Овоо суманд 32м/с хүрсэн байна.



Зураг 5. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд